ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ӨВА-2022/1/НА-СТА-ТШЗ**


Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Гансүх
Утас: 70323833 Цахим хаяг: Gansukh.audit@gmail.com
Аудитор: Р.Цэрэндолгор
Утас: 70323108 Цахим хаяг: Tserendolgorr@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn
Арвайхээр хот
2022 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/ ..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9
3. Аудитын тайлан ..... 9
3.1 Ерөнхий зүйл ..... 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 10
3.4 Материаллаг байдал ..... 10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 11
3.8 Аудитын гол асуудал ..... 12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 13
4. Аудитын илрүүлэлт ..... 13
4.1 Залруулсан алдаа ..... 13
4.2 Төлбөрийн акт ..... 13
4.3 Албан шаардлага ..... 13
4.4 Зөвлөмж ..... 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 13


## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.01.27 № 80

танай ________-ны №________-т

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ХАРЪЯА
ХАРХОРИН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН
ЦАГДААГИЙН ХЭЛТЭСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Г.ЧИМЭДДАГВА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

015030160

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| ДАНС | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 83,662,143.80 | 90,030,205.21 |
| 33 | АВЛАГА | 00.00 | 73,342.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 73,342.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 83,662,143.80 | 89,956,863.21 |
| 351 | Түүхий эд материал | 36,337,230.30 | 42,250,870.60 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 34,083,450.30 | 40,578,920.60 |
| 35130 | Эм боох материал | 2,253,780.00 | 1,671,950.00 |
| 354 | Хангамжийн материал | 47,324,913.50 | 47,705,992.61 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 12,026,273.00 | 5,085,215.11 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,354,062.00 | 1,859,625.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 10,660,941.00 | 9,463,279.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 4,395,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 82,450.00 | 52,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 23,201,187.50 | 26,850,373.50 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,284,231,372.37 | 1,350,626,701.14 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,284,231,372.37 | 1,350,626,701.14 |
| 392 | Биет хөрөнгө | 1,082,144,705.65 | 1,137,581,367.70 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,010,512,944.06 | 1,007,466,076.06 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -62,251,767.00 | -84,516,234.76 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 281,296,558.97 | 246,164,711.86 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -236,207,799.21 | -113,592,477.60 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 104,587,382.03 | 111,913,259.42 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -36,675,973.49 | -54,197,475.39 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 19,665,625.60 | 21,374,995.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -7,859,160.71 | -14,403,973.81 |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 7,783,562.00 | 7,783,562.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,365,000.00 | 12,170,130.64 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,071,666.60 | -2,581,206.32 |
| 393 | Биет бус хөрөнгө | 202,086,666.72 | 213,045,333.44 |
| 39301 | Програм хангамж | 250,000.00 | 250,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -83,333.28 | -166,666.56 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 201,920,000.00 | 212,962,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,367,893,516.17 | 1,440,656,906.35 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 00.00 | 73,342.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 00.00 | 73,342.00 |
| 413 | Өглөг | 00.00 | 73,342.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 73,342.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,367,893,516.17 | 1,440,583,564.35 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,367,893,516.17 | 1,440,583,564.35 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,277,970,565.33 | 1,289,012,565.33 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,277,970,565.33 | 1,289,012,565.33 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 89,922,950.84 | 151,570,999.02 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 89,922,950.84 | 89,922,950.84 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 61,648,048.18 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,367,893,516.17 | 1,440,656,906.35 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| ДАНС | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,153,352,994.05 | 1,312,692,692.18 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 95,966,490.05 | 175,423,292.18 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 95,966,490.05 | 175,423,292.18 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,748,869.00 | 14,425,400.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,267,600.00 | 10,276,650.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,481,269.00 | 4,148,750.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,057,386,504.00 | 1,137,269,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,051,649,200.00 | 1,114,590,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,051,649,200.00 | 1,114,590,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 5,737,304.00 | 22,679,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,737,304.00 | 22,679,300.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,180,810,403.60 | 1,251,044,644.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,180,810,403.60 | 1,251,044,644.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,175,300,571.60 | 1,247,226,862.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 881,241,549.00 | 925,067,286.00 |
| 210101 | Үндсэн цалин | 542,577,147.00 | 596,221,124.00 |
| 210102 | Нэмэгдэл | 338,664,402.00 | 328,446,162.00 |
| 210104 | Урамшуулал | - | 400,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,936,236.00 | 22,642,166.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,286,728.00 | 3,442,084.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 362,573.00 | 314,984.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 499,923.00 | 340,864.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 99,985.00 | 75,563.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,687,027.00 | 18,468,671.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 40,557,114.00 | 41,944,527.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,432,807.00 | 13,738,130.00 |
| 210302 | Түлш, халаалт | 24,447,097.00 | 25,264,907.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,677,210.00 | 2,941,490.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 65,668,795.00 | 88,972,548.89 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,101,942.00 | 7,601,596.89 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 51,510,308.00 | 66,824,558.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,225,747.00 | 4,023,359.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 90,000.00 | 30,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 80,000.00 | 180,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,660,798.00 | 2,797,527.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 7,514,708.00 |
| 2105 | Нормативт зардал | 21,275,340.00 | 13,580,330.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,221,840.00 | 1,636,830.00 |
| 210502 | Хоол, хүнс | 19,547,500.00 | 11,943,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 20,412,307.55 | 45,309,660.55 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,058,357.55 | 8,458,603.55 |
| 210604 | Урсгал засвар | 16,353,950.00 | 36,851,057.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,510,500.00 | 4,811,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,510,500.00 | 4,811,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,788,122.00 | 2,526,565.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,428,000.00 | 313,460.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 954,592.00 | 1,431,744.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 200,000.00 | 160,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 354,900.00 | 442,608.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 274,630.00 | 178,753.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 112,910,608.05 | 102,372,278.56 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 2,629,775.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 807,300.00 | 537,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 112,103,308.05 | 99,205,003.56 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,509,832.00 | 3,817,782.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,560,000.00 | 1,740,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 300,000.00 | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,260,000.00 | 1,440,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 3,949,832.00 | 2,077,782.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,949,832.00 | 2,077,782.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | - 27,457,409.55 | 61,648,048.18 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | - 27,457,409.55 | 61,648,048.18 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,277,970,565.33 | 00.00 | 117,380,360.39 | 1,395,350,925.72 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,277,970,565.33 | 00.00 | 117,380,360.39 | 1,395,350,925.72 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -27,457,409.55 | -27,457,409.55 |
| C08 | 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,277,970,565.33 | 00.00 | 89,922,950.84 | 1,367,893,516.17 |
| D01 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,277,970,565.33 | 00.00 | 89,922,950.84 | 1,367,893,516.17 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,277,970,565.33 | 00.00 | 89,922,950.84 | 1,367,893,516.17 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 11,042,000.00 | 00.00 | 00.00 | 11,042,000.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 61,648,048.18 | 61,648,048.18 |
| D09 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,289,012,565.33 | 00.00 | 151,570,999.02 | 1,440,583,564.35 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,071,654,104.00 | 1,147,546,050.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 14,267,600.00 | 10,276,650.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 14,267,600.00 | 10,276,650.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 14,267,600.00 | 10,276,650.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 14,267,600.00 | 10,276,650.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,057,386,504.00 | 1,137,269,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,051,649,200.00 | 1,114,590,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,051,649,200.00 | 1,114,590,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 5,737,304.00 | 22,679,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,737,304.00 | 22,679,300.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,071,654,104.00 | 1,147,546,050.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,071,654,104.00 | 1,147,546,050.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,066,144,272.00 | 1,143,728,268.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 879,842,029.00 | 927,697,061.00 |
| 210101 | Үндсэн цалин | 518,310,781.00 | 539,030,261.00 |
| 210102 | Нэмэгдэл | 361,531,248.00 | 388,266,800.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 400,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 24,335,756.00 | 22,642,166.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,070,500.00 | 22,642,166.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 43,973,134.00 | 47,715,007.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,432,807.00 | 13,738,130.00 |
| 210302 | Түлш, халаалт | 27,863,117.00 | 31,035,387.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,677,210.00 | 2,941,490.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 69,649,781.00 | 70,588,365.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,416,000.00 | 5,058,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 54,323,784.00 | 58,345,416.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,926,997.00 | 4,023,359.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,353,000.00 | 30,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 80,000.00 | 180,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,550,000.00 | 2,950,790.00 |
| 2105 | Нормативт зардал | 20,709,800.00 | 13,098,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 662,300.00 | 1,055,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 19,547,500.00 | 11,943,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 500,000.00 | 100,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 15,809,780.00 | 51,817,857.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,999,780.00 | 9,297,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,810,000.00 | 42,520,057.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,510,500.00 | 4,811,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,510,500.00 | 4,811,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,513,492.00 | 2,857,812.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,428,000.00 | 823,460.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 954,592.00 | 1,431,744.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 200,000.00 | 160,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 354,900.00 | 442,608.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,800,000.00 | 2,500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,800,000.00 | 2,500,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,509,832.00 | 3,817,782.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,560,000.00 | 1,740,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 300,000.00 | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,260,000.00 | 1,440,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 3,949,832.00 | 2,077,782.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,949,832.00 | 2,077,782.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ДАНС | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,065,325,200.00 | 1,065,316,968.00 | 1,125,766,100.00 | 1,122,788,968.00 | 99.74 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,065,325,200.00 | 1,065,316,968.00 | 1,125,766,100.00 | 1,122,788,968.00 | 99.74 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,063,765,200.00 | 1,063,756,968.00 | 1,124,026,100.00 | 1,121,048,968.00 | 99.74 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 877,720,700.00 | 877,719,981.00 | 928,927,500.00 | 927,297,061.00 | 99.82 |
| 210101 | Үндсэн цалин | 518,311,500.00 | 518,310,781.00 | 540,660,700.00 | 539,030,261.00 | 99.70 |
| 210102 | Нэмэгдэл | 359,409,200.00 | 359,409,200.00 | 388,266,800.00 | 388,266,800.00 | 100.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 24,070,500.00 | 24,070,500.00 | 22,700,800.00 | 22,634,166.00 | 99.71 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,070,500.00 | 24,070,500.00 | 22,700,800.00 | 22,634,166.00 | 99.71 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 43,973,700.00 | 43,973,134.00 | 47,723,700.00 | 47,715,007.00 | 99.98 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,432,900.00 | 13,432,807.00 | 14,589,800.00 | 13,738,130.00 | 94.16 |
| 210302 | Түлш, халаалт | 27,863,100.00 | 27,863,117.00 | 29,549,000.00 | 31,035,387.00 | 105.03 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,677,700.00 | 2,677,210.00 | 3,584,900.00 | 2,941,490.00 | 82.05 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 69,649,800.00 | 69,649,781.00 | 69,746,800.00 | 69,746,365.00 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,416,000.00 | 5,416,000.00 | 5,416,000.00 | 4,573,500.00 | 84.44 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 54,323,800.00 | 54,323,784.00 | 56,323,800.00 | 57,987,916.00 | 102.95 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,927,000.00 | 4,926,997.00 | 3,427,000.00 | 4,023,359.00 | 117.40 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,353,000.00 | 1,353,000.00 | 120,000.00 | 30,000.00 | 25.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 80,000.00 | 80,000.00 | 410,000.00 | 180,800.00 | 44.10 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,550,000.00 | 3,550,000.00 | 4,050,000.00 | 2,950,790.00 | 72.86 |
| 2105 | Нормативт зардал | 20,710,000.00 | 20,709,800.00 | 12,450,000.00 | 12,027,500.00 | 96.61 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 662,300.00 | 662,300.00 | 800,000.00 | 800,000.00 | 100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 19,547,500.00 | 19,547,500.00 | 11,550,000.00 | 11,127,500.00 | 96.34 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 500,200.00 | 500,000.00 | 100,000.00 | 100,000.00 | 100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 15,810,000.00 | 15,809,780.00 | 31,970,400.00 | 31,969,557.00 | 100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,000,000.00 | 3,999,780.00 | 4,450,000.00 | 4,449,500.00 | 99.99 |
| 210604 | Урсгал засвар | 11,810,000.00 | 11,810,000.00 | 27,520,400.00 | 27,520,057.00 | 100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,517,000.00 | 5,510,500.00 | 4,817,000.00 | 4,811,500.00 | 99.89 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,517,000.00 | 5,510,500.00 | 4,817,000.00 | 4,811,500.00 | 99.89 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,513,500.00 | 4,513,492.00 | 3,189,900.00 | 2,347,812.00 | 73.60 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,428,000.00 | 2,428,000.00 | 500,000.00 | 313,460.00 | 62.69 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 954,600.00 | 954,592.00 | 1,755,000.00 | 1,431,744.00 | 81.58 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 200,000.00 | 200,000.00 | 320,000.00 | 160,000.00 | 50.00 |
| 210807 | Газрын төлбөр | 354,900.00 | 354,900.00 | 614,900.00 | 442,608.00 | 71.98 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1800000.00 | 1800000.00 | 2500000.00 | 2500000.00 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,800,000.00 | 1,800,000.00 | 2,500,000.00 | 2,500,000.00 | 100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1560000.00 | 1560000.00 | 1740000.00 | 1740000.00 | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,560,000.00 | 1,560,000.00 | 1,740,000.00 | 1,740,000.00 | 100.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 300,000.00 | 300,000.00 | 300,000.00 | 300,000.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,260,000.00 | 1,260,000.00 | 1,440,000.00 | 1,440,000.00 | 100.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,065,325,200.00 | 1,065,316,968.00 | 1,125,766,100.00 | 1,122,788,968.00 | 99.74 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,051,649,200.00 | 1,051,049,368.00 | 1,114,590,100.00 | 1,112,512,318.00 | 99.81 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,051,649,200.00 | 1,051,049,368.00 | 1,114,590,100.00 | 1,112,512,318.00 | 99.81 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 13,676,000.00 | 14,267,600.00 | 11,176,000.00 | 10,276,650.00 | 91.95 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,676,000.00 | 14,267,600.00 | 11,176,000.00 | 10,276,650.00 | 91.95 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 64.00 | 62.00 | 67.00 | 67.00 | |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 61.00 | 59.00 | 64.00 | 62.00 | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 02.00 | 02.00 | 02.00 | 04.00 | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ДАНС | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 18,284,300.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 18,284,300.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 18,284,300.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 400,000.00 |
| 210104 | Урамшуулал | | 400,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 8,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 8,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 842,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 484,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 357,500.00 |
| 2105 | Нормативт зардал | | 1,071,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 255,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 816,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 15,453,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 4,848,300.00 |
| 210604 | Урсгал засвар | | 10,605,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 510,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 510,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 0.00 | 22679300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 22,679,300.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 15,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 7,679,300.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Цэрэндолгор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.02.07-ны өдрийн 01/05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс нь “Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.” гэж заасанаар тодорхойлогдоно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 1,251.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 12.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө болон бараа материалын тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө өмнөх оноос 66.4 сая төгрөгөөр өссөн нь аймгийн ЗДТГ-аас шилжүүлэн авсан 131.7 сая төгрөгийн автомашин, 8.2 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, 1.7 сая төгрөгийн тавилга хэрэгсэл ирсэнтэй холбоотой байна.
- Бараа материал өмнөх оноос 6.3 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан тусгай зориулалтын материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, ЦЕГ-т нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 1,095.3 сая төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 1,074.3 сая төгрөгөөр батлагджээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1147.5 сая төгрөгөөр санхүүжигдэн, 1147.5 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөцөөс 15.0 сая төгрөгийг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7.6 сая төгрөг нийт 22.6 сая төгрөгийг санхүүжүүлэн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 0.5 сая төгрөгийг, тээвэр шатахууны зардалд 0.3 сая төгрөг, урсгал засварт 10.6 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгсэлд 4.8 сая төгрөг, эм бэлдмэлийн хэрэгсэлд 1.0 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 0.8 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

### 3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс нь шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд ямар нэгэн зөрчил илрээгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

### 4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

### 4.3 Албан шаардлага

Байхгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хархорин сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 00 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Р.ЦЭРЭНДОЛГОР

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 09-НЫ ӨДӨР